



ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН МОНГОЛ УЛСАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

*Боловсруулсан: МБСГ, СХ-ийн эдийн засагч Д.Даваасүх
МБСГ, СХ-ийн эдийн засагч Д.Цэнддорж
Удирдаж зөвлөсөн: МБСГ, СХ-ийн захирал Н.Амар*

1. ХЯТАД УЛСЫН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Газар нутаг

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ) нь дэлхийн хамгийн их хүн ам суурьшсан, Орос болон Канад улсын дараа орох гурав дахь том газар нутагтай улсын нэг. Газар нутгийн хэмжээ нь 9 сая 600 мянган хавтгай дөрвөлжин метр квадрат бөгөөд Ази тивийн нийт газар нутгийн 21.9%-ийг эзлэн оршдог байна.

Хятад улс нь зүүн Азид оршиж, Хойд Солонгос, Орос, Монгол зэрэг улстай газраар, Өмнөд Солонгос, Япон, Тайвань улсуудтай далайгаар нийтдээ 14 улстай хиллэх бөгөөд хилийн зурвасын урт нь ойролцоогоор 22 мянган километр байдаг. Уулархаг бүс нутагтай баруун хэсэгт нийт хүн амын 6% амьдардаг бол зүүн хагаст нь нийт хүн амын 94% амьдардаг⁴⁸. Нийт газар нутгийн 70 орчим хувь нь уулархаг бөгөөд үүнээс 33% уул нуруу, 26% их хавтан, 10% нь толгод байдаг байна.

1.1.1. Газарзүйн байршил

Хятадын хойд болон өмнөд захын цэг хоорондоо 5,500 орчим километр бөгөөд хойд захын цэг нь Мүө Хе суурингаас хойших Хэй Лунжян мөрний гол, хамгийн өмнөд захын цэг нь Зен Му Аншад юм. Харин баруун захын цэг нь Узбеки уулын аманд байхад, хамгийн зүүн захын цэг нь Үссүри болон Хэй Лун Жян мөрний уулзвар дээр байдаг.

Зураг 1. Газарзүйн тогтоц



Эх үүсвэр: <http://www.trailsofindochina.com/>

2005 оны байдлаар нийт газар нутгийн 15% буюу 1 сая 400 мянган хавтгай дөрвөлжин газар нутгийг газар тариалангийн зориулалттай ашигласан байна. Байгаль орчны тогтоц, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалан буга, гөрөөс, баавгай, чоно, гахай зэрэг зэрлэг амьтад нь баруун, зүүн бүсийн хооронд ихээр нүүдэллэдэг байна.

Хятадад нийтдээ 50 мянга гаруй гол горхитой ба ихэнх нь баруунаас зүүн тийш урсаж Номхон далайд цутгадаг. Амазон болон Нили мөрний дараа орох дэлхийн гурав дахь том гол Янгци нь 6,300 километр урттай. Нийт газар нутгийн 40 орчим хувь нь хуурайшилттай бөгөөд ихэнх гол горхи нь цөлжилтөөс болж ширгэсэн байна.

⁴⁸ (Barry, 2007)

1.1.2. Уур амьсгал

Хятад улс нь уртраг, өргөрөг, далайн түвшнээс дээш өргөгдсөн байдал зэргээс хамаарч 22 мужийн цаг агаарын байдал харилцан адилгүй байдаг байна. Их газрын болон далайн уур амьсгал зонхилох бөгөөд борооны улирал нь ерөнхийдөө салхитай байдаг. Зуны туршид, зүүн Азийн халуун чийгтэй уур амьсгал зонхилдог. Өвөр Монгол болон Хейлонгжинг (Heilongjiang) мужид хамгийн хүйтэн байдаг бол Хайнань (Hainan) арал нь халуун орны уур амьсгалтай.

Өвөр Монгол болон Хейлонгжинг мужид нэгдүгээр сард дунджаар цельсийн -30 градус, харин долдугаар сард цельсийн +18 градусаас хэтэрдэггүй байна. Гэтэл Хайнан мужид нэгдүгээр сард цельсийн +17 градус, долдугаар сард цельсийн +28 градусаас дээш байдаг. Хятадын байгаль орчны гол асуудал нь цөлжилт бөгөөд дэлхийд хэмжээгээрээ тавд тооцогдох цөл тус улсад байдаг байна.

1.2. Засаг захиргааны зохион байгуулалт

БНХАУ нь Лаос, Вьетнам, Куб зэрэг улсуудтай адил дэлхий дээрх социалист системтэй дөрвөн улсын нэг юм. Хятадын засгийн газар нь интернет, хурал цуглаан хийх, хэвлэлийн эрх чөлөө, хүн амын нөхөн үржих эрх, шашин шүтэх эрх чөлөөг хязгаарладаг байна. Нэг намын тогтолцоотой бөгөөд нийгэм, эдийн засаг нь зах зээлийн эдийн засаг руу аажим шилжиж буй дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) хэмжээгээрээ дэлхийн хоёр дахь том эдийн засагтай гэгдэх орон юм⁴⁹.

Зураг 2. Засаг захиргааны нэгж



Сонгуулийн систем нь шаталсан хэлбэртэй, хууль тогтоох байгууллага нь Бүх Ардын төлөөлөгчдийн хурал, гүйцэтгэх засаглалын дээд байгууллага нь Төрийн зөвлөл юм.

Засаг захиргааны хувьд 22 мужтай бөгөөд Нэгдсэн Үндэсний Байгууллагын (НҮБ) гишүүн бус Тайванийг өөрийн 23 дахь муж хэмээн үздэг. Өөртөө засах 5 орон, төвөөс захирах 4 хот (Бээжин, Тяньжин, Шанхай, Чуньчунь), 2 онцгой эрхт нутгаас (Хонг Конг,

Эх үүсвэр: www.trailsofindochina.com/

Макао) бүрддэг. 1997 онд Англиас Хонконгийг, 1999 онд Португалиас буцааж авсан Макао нь “Нэг улс, хоёр систем” гэж нэрлэгдэхүйц өөртөө засах эрхтэй.

⁴⁹ www.wikipedia.org

1.3. Хүн ам


Хятад улс нь дэлхийн хамгийн их хүн амтай үндэстэн юм. Коммунист засгийн газар 1949 онд засгийн эрхэнд гарснаар хоол тэжээлийн дутагдал, хүн амын өвчлөлт зэрэгт анхаарал хандуулснаар нас баралтын түвшин буурах хандлагатай болсон байна. 1950-аад оны дунд үед төрөлтийн түвшин жилд дунджаар хамгийн багадаа хоёр орчим хувьтай байсан нь Хятадын хүн ам огцом өсөхөд гол нөлөө үзүүлсэн гэж судлаачид дүгнэдэг байна.

Тухайн үеийн хүн амын төрөлтийн түвшин буурахгүй байсан шалтгааныг өрхүүд хүүхдийн тоог чухалчлан үздэг байсантай холбон тайлбарладаг. 1950-1970 оны хооронд Хятадын хүн амын төрөлтийн оргил үе байсан бөгөөд тухайн үеийн жилийн дундаж төрөлтийн түвшин нь 2.5 орчим хувьтай байсан байна. Хүн амын төрөлтийн түвшин 1970-1981 оны хооронд ойролцоогоор 2.8%-1.3% хүртэл буурсан бөгөөд уг бууралтыг эдийн засагчид хүн ам зүйн шилжилттэй холбон тайлбарладаг.

Зураг 3-т Хятадын нийт хүн амын өсөлтийн түвшин, хот болон хөдөөний хүн амын динамикийг харуулсан. 1963-1969 оны хооронд хүн амын өсөлтийн түвшин дунджаар 2.6% хувьтай байсан бол 1972-1981 оны хооронд хүн амын өсөлт буурч 1.6%-д хүрсэн байна. Энэхүү өсөлтийн түвшин буурахад гол нөлөө үзүүлсэн хүчин зүйл Хятадын засгийн газраас хэрэгжүүлж эхэлсэн “Нэг өрх, нэг хүүхэд” бодлоготой шууд хамааралтай. 1981-1988 оны хооронд хүн амын өсөлтийн түвшин өсөх хандлагатай харагдаж байгаа нь 1960-аад оны дунд үеийн хүн амын өндөр өсөлтийн түвшинтэй холбоотой. Хүн амын тоо нэмэгдэхийн хирээр нэг километр квадрат нутагт ногдох хүний тоо улам бүр нэмэгдсээр байна.

Энэхүү үзүүлэлтийн хувьд 1961 онд нэг километр квадрат нутагт 70 хүн ногдож байсан бол дөчин жилийн дараа буюу 2011 он гэхэд хоёр дахин нэмэгдсэн төлөвтэй байна (Зураг 4).

Зураг 3. Нийт хүн ам, хүн амын өсөлтийн түвшин



Эх үүсвэр: www.data.worldbank.org


Засгийн газраас бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах, эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, эрүүл мэндийн суурь нөхцөлүүдийг сайжруулсны үндсэнд 1950 оны эхэн үед дундаж наслалт 41 байсан бол 2010 онд 73 болж өссөн дүнтэй байна (Зураг 4).

Зураг 4. Хүн амын нягтаршил, дундаж наслалт



Эх үүсвэр: www.data.worldbank.org

Зураг 5. Хүн амын насны суварга (2011)



Эх үүсвэр: Хятадын статистикийн газар 2011

Хятадын хүн амын насны бүтцийг 2011 оны байдлаар харуулсан бөгөөд 1996⁵⁰ оны хүн амын насны суваргатай харьцуулахад суурь нь нарийхан, гол хэсгээрээ өргөн бүтэцтэй болсон байна (Зураг 5).

2. ХЯТАДЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2.1. Бодит эдийн засаг

Хятадын эдийн засаг 1911 оныг хүртэл өндөр бүтээмжтэй уламжлалт хөдөө аж ахуйн салбараас ихээхэн хамааралтай байсан бөгөөд тухайн үед нийт хүн амын 90 орчим хувь хөдөө орон нутагт газар тариалан эрхэлж амьдарч байжээ. Өндөр бүтээмжтэй хөдөө аж ахуйн салбар нь хөдөлмөрийг ихээр шаардах болж, усжуулалтын суваг, үр тариагаа бордох зэрэг хүчин зүйлээс хамааралтай байсан. Хүн амын өсөлтийн түвшин нэмэгдэж, эдийн засгийн өсөлт явагдахын хэрээр хүн амыг хоол хүнсээр хангах асуудал тулгарсан нь өндөр бүтээмжтэй хөдөө аж ахуйн секторыг халах суурь болж өгчээ. 1911 оны хувьсгалын дараагаар нийгэм эдийн засгийн шинэ үе эхэлсэн нь 1912-1937 оны хоорондох аж үйлдвэржилтийн эхний суурийг тавьжээ. Өөрөөр хэлбэл эдийн засгийн бусад секторуудыг хөгжүүлэх, орчин үеийн аж үйлдвэржилтийн үе нь эхэлсэн байна.

Энэ хугацаанд хөдөө аж ахуй болон боловсролын салбарт хөрөнгө оруулалтыг засгийн газраас хийж эхэлсэн бөгөөд энэ үеийг “Нанжин”-гийн эрин үе гэж

⁵⁰ Хавсралт 71-ээс харна уу.


нэрлэдэг. 1933 онд Хятадын нийт хөдөлмөрийн хүчний 0.4% нь ажиллаж байсан хэдий ч дотоодын нийт бүтээгдэхүүний 2%-ийг үйлдвэрлэсэн бөгөөд 1912-1936 оны хооронд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлт нь 8-9% байжээ.

Бүх ардын хурал 1949 оны аравдугаар сард байгуулагдсанаас хойш социалист эринг (1949-1978) эхлүүлсэн байна. Энэхүү социалист эриний нөлөөгөөр 1952-1978 оны хооронд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлт 11.5%-тай байсан бөгөөд энэ хугацаанд дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хувийн жин 18%-44% хүрч өссөн бол хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь 51%-28% болтлоо буурсан дүнтэй байна. Мөн эдийн засгийн хөгжлийн стратегийг 1958-1972 оны хооронд боловсруулсан бөгөөд үүний эхнийх нь гадаад эдийн засгаас хамааралтай бус эдийн засгийн хурдацтай өсөлтийг бий болгох. Харин хоёр дахь зорилго нь барууны хөгжингүй орнуудын адил нэг хүнд ногдох орлого болон хүн амын амьдралын нөхцөлийг дээшлүүлэхэд чиглэгдэж байжээ.

Зөвлөлт холбоот улс болон БНХАУ-уудын эдийн засгийн хамтын ажиллагаа муудсаны үр дүнд ЗХУ-аас ирэх техник болон инженерийн туслалцаа тасарсан нь тухайн үеийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн байна. 1966-1968 оны хооронд “Соёлын хувьсгал” нэртэй хөдөлгөөнийг засгийн газраас өрнүүлж, их дээд сургуулиудыг хаасан нь боловсон хүчний дутагдалд ороход нөлөө үзүүлжээ (Зураг 6).

1976 онд Хятад улсын удирдагч Мао нас барсан, байгалийн гамшигт үзэгдэл болох газар хөдлөлт болсон зэрэг үйл явдал нь эдийн засгийн өсөлт буурахад гол нөлөө үзүүлсэн байна. 1990 оны эхэн үе болон сүүлийн хагаст мөн эдийн засгийн өсөлт удаашрахад Зөвлөлт холбоот улсын харьяа байсан улсууд тусгаар тогтнолоо зарласан, Азийн санхүүгийн хямрал зэрэг хүчин зүйлстэй холбоотой.


Зураг 6. Эдийн засгийн өсөлт



Эх үүсвэр: www.data.worldbank.org


2008 оны дэлхийн санхүү эдийн засгийн хямралын нөлөөгөөр эдийн засгийн өсөлтийн түвшин буурах хандлагатай болсон байна. Энэ үед Хятадын экспорт болон импорт буурсан, гадаадын шууд хөрөнгө оруулалт багассан, ажилгүйдлийн түвшин нэмэгдсэн зэрэг сөрөг үр дагавар эдийн засагт ихээр бий болж ирсэн байна. Хятадын эрх баригчид мөнгөний бодлогоо зөөлрүүлэх замаар 586 тэрбум долларыг зарцуулж, хэрэглээг дэмжин ажиллажээ. Үүний үр дүнд дэлхийн эдийн засгийн хямралыг огцом бууралтын нөлөөг сааруулж чадсан байна. Зураг 7-д дотоодын нийт бүтээгдэхүүнийг салбарын ангиллаар задлан харуулсан ба 1979 онд эдийн засгийн шинэчлэл хийснээс хойш, дотоодын нийт бүтээгдэхүүн дэх эдийн засгийн салбаруудын бүтэц өөрчлөгдөж эхэлсэн байна. 1978-1984 оны хооронд дотоодын нийт бүтээгдэхүүн дэх хөдөө аж ахуйн салбарын эзэлж буй хувь дунджаар 31%-тай байсан бол 2005-2011 оны хооронд 11% болтлоо буурсан дүнтэй байна.

Зураг 7. Дотоодын нийт бүтээгдэхүүн (салбараар)



Эх үүсвэр: www.data.worldbank.org

Зураг 8. Дотоодын нийт бүтээгдэхүүн (зардлын арга)



Эх үүсвэр: www.data.worldbank.org

Харин эсрэгээрээ үйлчилгээний салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 1978-1984 оны хооронд дунджаар 23%, 2005-2011 оны хооронд дунджаар 42% болж өсжээ⁵¹. Хятад улсын эдийн засаг 2013 оны байдлаар эдийн засгийн өсөлт явагдаж, үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарт өсөлт ажиглагдах хэдий ч хөдөө аж ахуйн салбарын өсөлт буурах хандлагатай байна.

⁵¹ Эдийн засгийн өсөлтөд салбаруудын үзүүлж буй нөлөөллийг Хавсралт 7-3-аас харна уу.

Шигтгээ 1.**Хятадын нүүрсний зах зээл**

Хүснэгт 1-т дэлхийн зах зээл дээрх нүүрсний үйлдвэрлэл болон хэрэглээг дүрслэн харуулсан байна. Хятад улс 2010-2012 оны хооронд дунджаар дэлхийн нүүрсний үйлдвэрлэлийн 45%-ийг үйлдвэрлэж байсан бол 2013-2014 оны хооронд дунджаар 47%-ийг үйлдвэрлэх төлөвтэй байна. Харин 2010-2012 оны хооронд дунджаар дэлхийн зах зээл дээрх нүүрсний хэрэглээний 48%-ийг мөн Хятад улс ганцаараа хэрэглэж байгаа бөгөөд 2013-2014 оны хооронд дунджаар 49%-ийг нь хэрэглэх төлөвтэй байна.

Хүснэгт 1. Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үйлдвэрлэл, хэрэглээ

Нүүрсний эрэлт, нийлүүлэлт (сая метрик тонн)	2010	2011	2012	2013*	2014*
Дэлхийн нүүрсний үйлдвэрлэл	7,244	7,678	7,870	8,133	8,458
Хятад	3,180	3,488	3,621	3,785	3,980
Дэлхийн нүүрсний хэрэглээ	7,253	7,694	7,828	8,110	8,372
Хятад	3,352	3,67	3,825	3,986	4,165
Тэнцэл	-9	-16	43	24	86

Эх үүсвэр: *World Bank; Economist Intelligence Unit*

Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнийг доорх хүснэгтээр харуулсан бөгөөд 2013-2014 оны хооронд нэг метрик тонн нүүрсний үнэ дунджаар 107 доллар байх төлөвтэй байна. Хятад улс нь дэлхийн зах зээл дээрх нүүрсний үйлдвэрлэл болон хэрэглээний гол тоглогч улс болсон нь дээрх хүснэгтээс харагдаж байгаа бөгөөд Хятадын эдийн засгийн төлөв байдлаас хамаарч дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ хэлбэлзэх хандлага ихээхэн ажиглагдах болсон (EIU report (2013)).

Хүснэгт 2. Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ (доллар/метрик тонн)

Нүүрсний үнэ ⁵²	2010	2011	2012	2013*	2014*
Нэгдүгээр улирал	128.99	113.65	93.00	105.00	110.00
Хоёрдугаар улирал	120.57	95.54	92.00	102.00	115.00
Гуравдугаар улирал	121.32	89.40	96.00	105.00	
Дөрөвдүгээр улирал	114.91	86.87	98.00	108.00	
Жилийн эцэст	121.45	96.36	94.75	105.00	
Жилийн өөрчлөлт	22.7	20.65	1.68	0.82	

Эх үүсвэр: *World Bank; Economist Intelligence Unit.*⁵²


2.2. Төсөв

Зураг 9-д Засгийн газрын орлого болон зардал, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн тэнцлийн эзлэх хувийг дүрслэн харуулсан байна. 2000-2011 оны хооронд төсвийн тэнцэл алдагдалтай буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 1.5% орчим хувийг эзэлж байна. 2000-2007 оны хооронд Хятадын засгийн газар төсвийн алдагдалтай байсан хэдий ч төсвийн алдагдлыг бууруулах бодлого баримтлан ажилласны үр дүнд 2007 онд төсвийн тэнцэл ашигтай гарсан байна.

⁵² Австралийн нүүрсний зах зээлийн ханш

Харин 2008-2009 оны хооронд дэлхийн санхүү эдийн засгийн хямралын нөлөөгөөр гадаад худалдаа буурсан, эдийн засгийн өсөлт буурч байсан тул засгийн газраас эрэлтийг урамшуулах бодлого хэрэгжүүлж засгийн газрын зардлаа нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд дахин төсвийн алдагдалтай гарсан хэдий ч, дэлхийн санхүү эдийн засгийн хямралын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгаж чадсан байна⁵³.

Зураг 9. Засгийн газрын орлого, зардал



Эх үүсвэр: Азийн хөгжлийн банк

Шинжээчдийн үзэж байгаагаар 2012 онд төсвийн алдагдал (ДНБ-д эзлэх %) 1.6% байна гэж үзэж байгаа бөгөөд 2013-2017 оны хооронд 1.7% болтлоо өсөх хандлагатай байна гэж таамаглаж байна. Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарт төсвөөс ихээр мөнгө зарцуулахаар төлөвлөжээ⁵⁴.

2.3. Эдийн засгийн хурдацтай өсөлтийн шалтгаан

Хятад улсын эдийн засгийн хурдацтай өсөлтийн шалтгаан нь юу байсан бэ? гэдэг асуулт дээр судлаачид ихээхэн маргадаг бөгөөд дараах нийтлэг хариултыг олсон байна. Хятад улс 34 жилийн өмнө буюу 1979 онд эдийн засгийн шинэчлэл хийснээс хойш дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж буй орны тоонд орж чадсан байна. Эдийн засгийн энэхүү хурдацтай өсөлтийн шалтгааныг олон улсын эдийн засагч, эрдэмтэн судлаачид дотоодын хадгаламж болон гадаадын шууд хөрөнгө оруулалтаар санхүүжсэн их хэмжээний хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хурдацтай өсөлттэй холбон тайлбарладаг.

Эдийн засгийн шинэчлэл хийх үед дотоодын хадгаламжийн хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүний 32%-тэй тэнцэж байсан бөгөөд эдгээр хадгаламжууд нь төрийн өмчийн байгууллагуудын бий болгосон ашиг байсан. Эдийн засгийн шинэчлэл хийсний үр дүнд өрхүүдийн болон төрийн өмчийн байгууллагуудын

⁵³ (Morrison, 2013)


⁵⁴ (Economist Corporate Network, 2011)

хуримтлалыг нэмэгдүүлж чадсан байна.

Их хэмжээний хадгаламж нь Хятадын дотоодын хөрөнгө оруулалтыг хурдацтай өсгөхөд түлхэц үзүүлсэн бөгөөд 2010 оны байдлаар дотоодын хадгаламж болон дотоодын нийт бүтээгдэхүүний хоорондох харьцаа 54 орчим хувьд хүрсэн дүнтэй байна. Эдийн засгийн өсөлт нь хурдацтай өсөхөд нөлөөлсөн өөр нэгэн хүчин зүйл нь үйлдвэрлэлийн өсөлт юм. Засгийн газрын хараа хяналтад байсан салбарууд болох үйлчилгээ, худалдаа, хөдөө аж ахуйн салбаруудын нөөцийг үр ашигтай дахин хуваарилсантай шууд холбоотой гэж эдийн засагчид үздэг. Тодруулбал, хувийн байгууллагуудын үйл ажиллагааг ихээр дэмжин ажиллаж, өрсөлдөөнийг бий болгох замаар пүүсүүдийн бүтээмжийг нэмэгдүүлсэн байна. Өндөр хөгжилтэй орнуудын өндөр хөгжсөн технологийг эдийн засагтаа хурдацтай нэвтрүүлснээр хөдөлмөр болон капиталын бүтээмжийг ихээр өсгөсөн нь эдийн засгийн хурдацтай өсөлтийн суурь болсон байна.


1991-1994 оны хоорондох эдийн засгийн хурдацтай өсөлтийн шалтгаан нь 1991 онд дотоодын нийт бүтээгдэхүүн 1.2 орчим хувийг эзэлж байсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ (цэвэр) 1992 онд 6.2% болтлоо өссөнтэй холбоотой (Зураг 10). 2009 онд хөрөнгө оруулалт буурч, эдийн засгийн өсөлт нь удаашрахад гол нөлөө үзүүлсэн бөгөөд 2013 онд нийт тогтмол хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэх хандлагатай байна.

Зураг 10. Гадаадын шууд хөрөнгө оруулалт



Эх үүсвэр: www.data.worldbank.org

Зураг 11. Нийт хөрөнгө оруулалт (салбараар)



Эх үүсвэр: Хятадын статистикийн газар 2011

Зураг 11-д 2003-2011 оны хоорондох нийт хөрөнгө оруулалтыг салбаруудаар харуулсан бөгөөд 2007 оны байдлаар боловсруулах аж үйлдвэрийн салбарт 32%, үл хөдлөх хөрөнгөнд 24%-ийн хөрөнгө оруулалт тус тус хийсэн байна. Харин 2011 оны байдлаар боловсруулах аж үйлдвэрийн салбарт 33%, үл хөдлөх хөрөнгийн салбарт 26%-ийн хөрөнгө оруулалт хийж 2007 оноос өссөн байдалтай байна.

3. ХЯТАДЫН САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ


3.1. Санхүүгийн зах зээл

Төрийн өмчит байгууллагуудад хөрөнгө оруулалт ихээр хийж буй нь эдийн засгийн хурдацтай өсөлтийн үндэс болж өгсөн байна (Зураг 12). Учир нь санхүүгийн системд капиталын үр ашигт байдлыг тэнцвэртэй тараажээ. Санхүүгийн зах зээлийн үүрэг нь бизнесийн байгууллагуудыг санхүүжүүлэх байсан бөгөөд өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд санхүүжилтийн хэмжээг өсгөсөн байна.

Дэлхийн санхүү эдийн засгийн хямралын дараа санхүүгийн зах зээл дээрх хөрөнгийн зах зээлийн эзлэх хувь өсөх хандлагатай байна⁵⁵. Хятадын санхүүгийн системд банкны салбар голлох үүрэг гүйцэтгэх бөгөөд 2018 оны сүүл гэхэд шинэ Basel III-ийн хөрөнгийн шаардлагыг хангахаар ажиллаж байна. Зарим банкуудын хувьд 2012 оны 9 дүгээр сар гэхэд 2018 оны зорилтод түвшиндээ хүрсэн төлөвтэй байна.


Зураг 13-т Шанхайн хөрөнгийн биржийн индексийг харуулсан бөгөөд эхний зураас буюу 2007-2008 оны хоорондох индекс өсөлт нь тухайн үеийн хөрөнгийн зах зээлийн хөөсрөлтийг харуулж байна. Харин 2008-2009 хооронд Шанхайн хөрөнгийн биржийн индекс уналтад орсон бөгөөд энэ нь тухайн үеийн дэлхийн санхүү эдийн засгийн хямралтай давхцаж байгаа юм. 2009 оноос хойш ерөнхийдөө хөрөнгийн зах зээл сэргэх хандлагатай болж байгааг доорх зурагнаас харж болохоор байна.

Зураг 12. Дотоодын нийт хадгаламж



Эх үүсвэр: www.data.worldbank.org

Зураг 13. Шанхайн хөрөнгийн биржийн индекс




Эх үүсвэр: www.data.worldbank.org

⁵⁵ Хавсралт 7-6-аас харна уу.

3.2. Мөнгөний бодлого

Зураг 14-т мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт болон мөнгөний нийлүүлэлт дотоодын нийт бүтээгдэхүүний харьцааг харуулсан болно. 2008 оны дэлхийн санхүү эдийн засгийн хямралын нөлөөгөөр гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсантай холбоотойгоор эрх баригчид нь мөнгөний зөөлөн бодлого явуулж хэрэглээг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийн бууралтыг сааруулж чадсан байна.

Зураг 14. Мөнгөний нийлүүлэлт




Эх үүсвэр: www.data.worldbank.org


Зураг 15-д Хятадын инфляцийн түвшинг 2004-2012 оны хооронд улирлаар харуулсан бөгөөд 2008 онд инфляцийн түвшин өссөн шалтгааныг нь тухайн үеийн эдийн засгийн хэт халалттай холбон тайлбарладаг. Харин 2009 онд дэлхийн санхүү эдийн засгийн хямралын нөлөөгөөр дефляцитай гарч эхэлсэн бөгөөд засгийн газраас эрэлтийг урамшуулах бодлого хэрэгжүүлсэн байна. Энэхүү эрэлтийг урамшуулах бодлогын үр нөлөө 2011 онд илэрч инфляцийн түвшинг бага зэрэг хөөрөгдсөн байна. Одоогийн байдлаар⁵⁶ Хятад улсад инфляцийн дарамт бага байгаа бөгөөд Хятадын Төв банк буюу Ардын банк 2013 оны дөрөвдүгээр улирлаас эхлэн бодлогын хүүгээ нэмэх төлөвтэй байна. Бодлогын хүүгээ нэмж буй шалтгаан нь үл хөдлөх хөрөнгийн үнэ өссөн, засгийн зардал нэмэгдсэн зэрэг хүчин зүйлтэй холбон тайлбарлаж байна.

⁵⁶ 2013 оны 5 сарын байдлаар

Зураг 15. Инфляци




Зураг 16. Хадгаламж, зээлийн хүү



Эх үүсвэр: OECD Economic Surveys China (2013) Эх үүсвэр: www.data.worldbank.org


Урсгал тэнцэл болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлт буурсан зэргээс үүдэн гадаад валютын зах зээл ихээхэн өөрчлөлттэй байсан. 2012 оны 12 дугаар сарын байдлаар гадаад валютын нөөцийн хэмжээ 3.1 их наяд ам доллартой бөгөөд ДНБ-ний 39 орчим хувьтай тэнцүү байна (Зураг 16).

Зураг 17. Валютын ханш (usd/yuan)



Эх үүсвэр: www.data.worldbank.org

Зураг 18. Гадаад валютын нөөц



Эх үүсвэр: OECD Economic Surveys China (2013)

1997 оны Азийн санхүүгийн хямралын үед Хятад улс дефляцитай байсан бөгөөд тухайн үед засгийн газраас дэд бүтцийн салбарт ихээхэн хөрөнгө оруулалт хийх замаар ханшаа тогтмол түвшинд барьж чадсан байна (Зураг 17). 2005 оны 7 сарын 21-ны өдөр хөвөгч ханшийн системтэй болсон бөгөөд энэ нь АНУ-ыг гадаад худалдааны ихээхэн алдагдалд оруулсан байна.


4. ХЯТАДЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТОЙМ

4.1. Экспорт, импорт

Хятадын худалдааны хамгийн том түнш улсуудыг доорх зурагнуудад харуулав (Зураг 19, Зураг 20). Хятадын экспортын хэмжээ 1979-2011 оны хооронд 14


тэрбум ам.доллараос 1.9 их наяд ам.доллар болтлоо өсжээ. 1990-2011 оны хооронд экспортын жилийн дундаж өсөлт 19.5%, импортын жилийн дундаж өсөлт 18.4% байсан. Экспорт болон импортын хэмжээ 2009 онд дэлхийн санхүү эдийн засгийн хямралын нөлөөгөөр буурсан. 2009 онд Хятад нь Герман улсыг гүйцэж дэлхийн хамгийн том экспортлогч улс болсон бөгөөд дэлхийн хоёрдогч том импортлогч гүрэн юм.

Зураг 19. Экспорт, улсуудаар (хувь)



Эх үүсвэр: Азийн хөгжлийн банк


Зураг 20. Импорт, улсуудаар (хувь)



Эх үүсвэр: Азийн хөгжлийн банк

2004-2008 онуудын хооронд гадаад худалдааны илүүдэлтэй байсан боловч 2009-2011 онд буурсан хандлагатай байна. 2008 онд худалдааны тэнцэл хамгийн өндөр цэгтээ буюу 298.1 тэрбум ам.доллар байсан бол 2009 онд 195.7 тэрбум болж буурчээ. Гадаад худалдааны хувьд экспорт болон импорт нэмэгдэж, юанийн ханш 2013 оны сүүлийн хагаст долларын эсрэг чангарах төлөвтэй байна.

Зураг 21. Гадаад худалдааны тэнцэл (их наяд доллар)



Эх үүсвэр: Хятадын статистикийн газар 2011

Хятадын хямд өртөгтэй ажиллах хүч нь олон улсад өрсөлдөхүйц үйлдвэрлэгч болгож чадсан бөгөөд 2010 оны байдлаар дунджаар 1 цагийн ажлын хөлс 2

ам.доллар байсан. Энэхүү үзүүлэлт АНУ-ын хувьд 35 ам.доллар байдаг. Хятадын импортлож авдаг бүтээгдэхүүнүүд нь ихэвчлэн жижиг тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл байдаг бөгөөд үүнийгээ нийлүүлж угсраад эцсийн бүтээгдэхүүн болгосны дараа экспортод гаргадаг байна (Хүснэгт 3, Хүснэгт 4).

Хүснэгт 3. Экспортын гол бараа бүтээгдэхүүн (2011)

Тайлбар	Тэрбум доллар	Хувийн жин	Өөрчлөлтийн хувь 2011/2010
Нийт экспорт	1,899.3	100	20.3%
Электрон бараа (компьютер, түүний дагалдах хэрэгсэл)	445.8	23.5	14.6%
Машин механизм	353.9	18.6	14.2%
Нэхмэл хувцас	80.2	4.2	20.2%
Сүлжмэл хувцас	63.1	3.3	16%
Оптик, фото, кино зураг авалт, эмнэлэг ба мэс заслын багаж, аппарат, сэлбэг дагалдах хэрэгсэл	60.7	3.2	16.5%
Тавилга	59.4	3.1	17.3%
Төмөр ба гангийн бүтээгдэхүүн	51.2	2.7	30.8%
Төмөр замаас бусад машин, тоног төхөөрөмж	49.6	2.6	29.2%
Хуванцар	45.5	2.4	30.9%
Усан онгоц	43.7	2.3	8.5%

Эх үүсвэр: (Morrison, 2013)

Хүснэгт 4. Импортын гол бараа бүтээгдэхүүн (2011)

Тайлбар	Тэрбум доллар	Хувийн жин	Өөрчлөлтийн хувь 2011/2010
Нийт импорт	1,741.4	100	24.9%
Электрон бараа	351.0	20.2	11.6%
Ашигт малтмал, газрын тос	273.5	15.7	45.2%
Машин механизм	199.6	11.5	15.8%
Хүдэр	150.7	8.7	39.5%
Оптик, фото, кино зураг авалт, эмнэлэг ба мэс заслын багаж, аппарат, сэлбэг дагалдах хэрэгсэл	65.3	3.8	32.2%
Хуванцар	70.2	4.0	10.2%
Химийн бүтээгдэхүүн	63.2	3.6	31.0%
Зэс	54.3	3.1	18%
Онцгой ангиллын бүтээгдэхүүн	49.5	2.8	168.5%

Эх үүсвэр: (Morrison, 2013)

5. ХЯТАДЫН НИЙГМИЙН САЛБАРЫН ТОЙМ


5.1. Орлого хуваарилалт, жини индекс

2010 оны OECD⁵⁷-ийн Хятадын эдийн засгийн тойм судалгаагаар орлогын тэгш бус байдал өндөр байсан. Хятадад орлогын тэгш бус байдал өндөр байгаа хэдий ч өмнөх онуудтай харьцуулахад өсөлт нь буурсан байна. 2013 оны нэгдүгээр сард Хятадын статистикийн үндэсний хорооноос өнгөрсөн 10 жилийн хугацаанд анх удаагаа нэг хүнд ногдох орлогын тэгш бус байдлын судалгааг хийжээ. Судалгаагаар 2008 онд нэг хүнд ногдох орлогын тэгш бус байдал оргил цэгтээ хүрсэн бөгөөд харин буурах хандлагатай байна. Орлогын тэгш бус байдал нэмэгдэхэд хэд хэдэн хүчин зүйл гол нөлөө үзүүлсэн байна.


⁵⁷ Эдийн засгийн хамтын ажиллагааны орнууд

Хотын бүсэд өнгөрсөн хэдэн жилийн хугацаанд орлогын тэгш бус байдал буурах хандлагатай байгаа бөгөөд үүнд эрүүл мэндийн халамж, цалингийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Хүн амын нийт орлогын 10% болон 90%-ийг эзэмшиж байгаа өрхүүдийн орлогын харьцаа хотын бүсэд буурах хандлагатай байна.

Зураг 22. Жини коэффициент



Эх үүсвэр: OECD Economic Surveys China (2013)

Зураг 23. Өрхийн орлогын тэгш бус байдал⁵⁸

Эх үүсвэр: OECD Economic Surveys China (2013)

Улсын хэмжээнд энэхүү харьцаа мөн буурах хандлагатай байна. Өнгөрсөн хэдэн жилийн хугацаанд бүс нутгуудын хоорондох орлогын тэгш бус байдал буурч, улмаар мужуудын ядуу хэсгийн орлогын өсөлт болон бүтээмж дээшилсээр байна. Далайд гарцгүй бүс нутагт шинээр үйлдвэрүүд баригдсанаар, далайн эрэг хавийн бүс нутаг руу шинээр суурьших иргэдийн хөдөлгөөн буурсан дүр зурагтай байна. 2011 он гэхэд, 1990 оны орлогын тэгш бус байдалтай харьцуулахад буурсан байна. 2013 оны 2 дугаар сард хэрэглээний өсөлт болон орлогын тэгш бус байдлын талаар бүс нутгийн засаг захиргааны нэгж, нийгмийн хамгаалал хүний нөөцийн яам, сангийн яам, үндэсний хөгжил шинэтгэлийн хороо зэрэг байгууллагууд хуралдсан байна.

Хуралдааны гол зорилго нь өрх гэрийн орлогын түвшинг өсгөх гурван санал боловсруулсан байна. Үүнд: 1) санхүүгийн зах зээлийн шинэчлэлийг тасралтгүй хэрэгжүүлэх бөгөөд зээлийн хүүний түвшинг бууруулж, урт хугацаат болон богино хугацааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, 2) төрийн өмчид байгууллагуудын ашгийн нормыг нэмэгдүүлж дотоодын нийт бүтээгдэхүүний 0.15%-д хүргэх, 3) 2015 он гэхэд засгийн газрын зүгээс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг одоогийн түвшнээс 40% өсгөх төлөвлөгөөтэй байна.

5.2. Засаглалын чанар

Засаглал нь тухайн улсын аливаа төрийн байгууллагын нийгмийн сайн сайхны төлөө хэрэгжүүлж буй бодлого болон институциудаар тодорхойлогдоно гэж

⁵⁸ Хүн амын орлогын 10% болон 90%-ийг эзэмшиж байгаа өрхүүдийн харьцаа

үзжээ (Kaufmann, 2005). Дэлхийн банк, Дэлхийн эдийн засгийн форум зэрэг олон улсын судалгааны байгууллагууд засаглалын чанарыг хэмжих тал дээр нэлээдгүй судалгааны ажил хийсэн байна.

Хүснэгт 5. Засаглалын чанар

Засаглалын индекс	2005	2006	2007	2008	2009	2010	2011
Дуу хоолой ба хариуцлагатай байдал ⁵⁹	-1.50	-1.69	-1.67	-1.65	-1.65	-1.63	-1.64
Улс төрийн тогтвортой байдал ⁶⁰	-0.49	-0.57	-0.52	-0.51	-0.55	-0.76	-0.70
Засгийн газрын үр ашигт байдал ⁶¹	-0.09	0.12	0.22	0.19	0.13	0.12	0.12
Зохицуулалтын байдал ⁶²	-0.13	-0.19	-0.16	-0.14	-0.19	-0.21	-0.20
Хуулийн хэрэгжилт ⁶³	-0.49	-0.57	-0.47	-0.35	-0.34	-0.35	-0.43
Авилгын хяналт ⁶⁴	-0.64	-0.51	-0.59	-0.54	-0.54	-0.61	-0.62

Эх үүсвэр: www.info.worldbank.org

Дэлхийн банкны хувьд засаглалын чанарыг тодорхойлж, хэмжих чиглэлд маш олон судалгааны ажил хийсэн бөгөөд үүний үр дүнд 1996 оноос хойш засаглалын чанарыг гурван үндсэн талбарт хэмжиж эхэлсэн байна. Тэд засаглалын чанарыг хэмжихдээ 6 үзүүлэлтийн хувьд харьцуулалт хийх замаар засаглалын чанарыг тодорхойлсон байна.

Эдгээр 6 засаглалын үзүүлэлт тус бүр -2.5-аас 2.5-ийн хооронд тоон утгаа авах ба 2.5 руу ойрхон байх тусам тухайн улсын засаглалын чанар сайн байгааг илтгэнэ. Эсрэг тохиолдолд тухайн улсын аль нэг засаглалын индексийн тоон утга -2.5 руу ойр байснаар институцийн чанар доогуур түвшинд байгааг харуулна.

Хүснэгт 5-д Хятад улсын засаглалын индексийг харуулсан бөгөөд 2011 оны байдлаар 6-н индикатораас 5-н индикатор нь сөрөг утгатай буюу засаглалын чанар доогуур байгааг илтгэж байна. Засгийн газрын үр ашигт байдал буюу нийгмийн үйлчилгээний чанар, засгийн газрын амлалтад итгэх итгэлийг илэрхийлсэн индекс эерэг утгатай байна.

⁵⁹ Улс төр, соёлын болон хүний эрхийг илэрхийлнэ.

⁶⁰ Засгийн газарт учирч болох буюу төрийн өөрчлөлтөд хүргэж болох хүчирхийллийн аюул заналыг харуулдаг.

⁶¹ Нийгмийн үйлчилгээний чанар, улс төрийн дарамтаас иргэд ангид байх боломж, нийгмийн бодлогын томъёолол болон хэрэгжүүлэлтийн чанар, Засгийн газрын амлалтанд итгэх итгэлийг илэрхийлнэ.

⁶² Засгийн газрын зөв эдийн засгийн бодлого томъёолох, хэрэгжүүлэх чадвар болон хувийн секторын хөгжлийг урамшуулах зохицуулалтыг харуулна.


⁶³ Эдийн засгийн агентуудын нийгэмд үйлчилж байгаа хуульд итгэлтэй байх ба сахин биелүүлдэг байх, ялангуяа цагдаа, шүүх, гэрээний биелэлтийн чанарыг илэрхийлнэ.

⁶⁴ Төрийн эрх мэдлийг өөрийн хувийн эрх ашиг, сонирхлын төлөө ашиглах явдал болон түүний дотор том, жижиг авилгын аль алиныг нь, хэргийн илрүүлэлтийг харуулдаг.


5.3. Ажиллах хүч, ажилгүйдлийн түвшин

Хөдөлмөрийн зах зээлийг Хятадын засгийн газраас хянаж байсан бөгөөд хөдөлмөрийн насны хүн ам хот, хөдөө ажиллах гэсэн хоёрхон сонголттой байсан бол 1990 оны дунд үеэс эхлэн энэхүү байдал өөрчлөгдөж эхэлсэн байна. 2011 оны байдлаар 764 сая хүн хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд нийт ажиллагсдын 35% нь хөдөө аж ахуйн салбар, 30% нь үйлдвэрлэлийн салбар, үлдсэн 36% нь үйлчилгээний салбарт тус тус ажиллаж байна.

Зураг 24. Нийт ажиллагсад



Зураг 25. Ажиллагсад (салбараар)



Эх үүсвэр: Хятадын статистикийн газар (2011) Эх үүсвэр: Хятадын статистикийн газар (2011)


Харин 2006 онд эдийн засгийн идэвхтэй хүн ам 763 сая байсан бол 2011 оны байдлаар 785 саяд хүрсэн байна. Хотын ойролцоо бүс нутгуудад бүртгэлтэй ажилгүйчүүдийн хувь 2009 онд 4.3%, 2011 онд 4.1% болж буурсан хандлагатай байна.

Шигтгээ 2.

Цалингийн дундаж түвшин

Зураг 26-д Хятад улсын салбаруудын дундаж болон улсын дундаж цалинг харуулсан болно. Салбаруудын дундаж цалингийн түвшин 2003-2011 оны хооронд өсөх хандлага ажиглагдаж байгаа бөгөөд мэдээллийн технологи болон санхүүгийн зуучлалын салбарын цалингийн түвшин бусад салбаруудаас хурдацтай өссөн дүр зураг ажиглагдаж байна.

Зураг 26. Салбаруудын жилийн дундаж цалин



Эх үүсвэр: Хятадын статистикийн газар (2011)

Хятадын засгийн газрын 12 дахь жилийн таван жилийн төлөвлөгөөнд улсын дундаж цалингийн түвшин 2015 он гэхэд 40 хүртэл хувиар нэмэгдүүлэх төлөвтэй байгаа. Барилгын салбарын жилийн дундаж цалингийн түвшин нь 2011 оны байдлаар дунджаар 32 мянган юань байна. Барилга болон хөдөө аж ахуйн салбарын жилийн дундаж цалингийн түвшин нь улсын дунджаас доогуур байгаа шалтгаан нь хөдөлмөр эрхэлж буй ажилчдаас ур чадвар бага шаарддагтай холбоотой байх талтай.

6. ХЯТАД, МОНГОЛЫН ХАРИЛЦАА

6.1. Хятад ба Монголын эдийн засаг



Монгол Хятад хоёр улс эрт дээр үеэсээ эдийн засаг, түүх, соёлын харилцаатай улсууд билээ. Хоёр улсын хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд улс төр, нийгэм, эдийн засгийн хүрээнд харилцан ашигтайгаар өрнөж тэр дундаа худалдаа, хөрөнгө оруулалтын салбарт эрчимтэй сайжирч байна. Одоогоор хоёр орны хооронд худалдаа хөрөнгө оруулалтыг зохицуулах хүчин төгөлдөр хэрэгжиж буй 100 гаруй гэрээ хэлэлцээр байгаа бөгөөд хоёр орны харилцаа түүхэн дээд шатандаа явж байна гэж хэлж болно.

БНХАУ болон Монгол хоёр орон 1949 оны 10-р сарын 16-ны өдөр дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр орны харилцаа зарим нугарал бүдрэлийг өнгөрөөсөн боловч найрсаг хөршийн харилцаа нь гол шугам болсоор ирсэн. Хоёр орны хооронд нөхөрсөг хамтын ажиллагааны гэрээ 1994 онд Улаанбаатарт батлагдсан нь хоёр орны харилцааг сайжруулах чухал алхам болсон ба хоёр улс хоорондын харилцаагаа 2003 онд харилцан итгэлцэлд суурилсан нөхөрсөг хөршийн харилцаа хэмээн тодорхойлсон. Монгол Улс, БНХАУ-ын ЗГ-уудын хамтарсан худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны ажлын хэсэг 1991 оноос хойш тогтмол уулзалт зохион байгуулах замаар худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг ханган ажилладаг.



6.2. Гадаад худалдаа

Хятад улс нь Монгол Улсын худалдааны хамгийн том түнш болох доорх зурагнуудаас (Зураг 27, Зураг 28) харагдаж байгаа бөгөөд 1990 онд Монгол Улсын БНХАУ-тай хийсэн худалдаа нийт худалдааны эргэлтийн 1.5 хувь байсан бол 2012 онд энэ нь 53.0 хувь болон нэмэгджээ⁶⁵. Хятад улс Монгол Улсыг Тяньжинь хотын боомтоор дамжуулан Ази Номхон далайн болон бусад далайгаар дамжин худалдаа хийх бололцоо олгодог. Хятад улс руу 2005 оны байдлаар экспортын 48%-ийг, 2013 оны 1-р сарын байдлаар экспортын 91%-ийг гаргасан байна.

⁶⁵

Зураг 27. Экспорт, улсуудаар (хувь)*Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо***Зураг 28. Импорт, улсуудаар (хувь)***Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо*

Монгол Улсаас Хятад улсад голлон уул уурхайн бүтээгдэхүүн, түүхий эд экспортолдог (Зураг 29) бол БНХАУ-аас Монгол Улсад хүнсний бүтээгдэхүүн хоол хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдаалдаг байна (Зураг 30). Зэсийн баяжмал 2006 оны байдлаар нийт экспортын 41%, 2011 оны байдлаар 20%-ийг тус тус экспортод гаргажээ. Орос улсаас түлш, бензин импортоор оруулж ирдэг бөгөөд 2013 оны 1-р сарын байдлаар нийт импортын 41% нь түлш, бензин импортоор оруулж ирсэн байна.

Зураг 29. Экспортын гол бараа бүтээгдэхүүн (хувь)*Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо***Зураг 30. Импортын гол бараа бүтээгдэхүүн (хувь)***Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо*


Өргөн хэрэглээний бараа болон хоол хүнсний бүхий л бүтээгдэхүүнийг Хятад улсаас импортоор авч байгаа тул Хятад улсын инфляцийн түвшин манай улсын инфляцийн түвшинд нөлөөлөх магадлалтай.

Шигтгээ 3.

Инфляцийн хамаарал

Зураг 31-д Монгол болон Хятад улсын 2004-2012 оны хоорондох инфляцийн динамикийг харуулсан бөгөөд зурагнаас харахад манай улсын инфляци Хятад улсын инфляцийн хандлагатай төстэй байна. Тодруулбал, Хятадын инфляцийн түвшин өсвөл тодорхой хугацааны дараа манай улсын инфляци өсч байгаа нь харагдаж байна.

Зураг 31. Инфляцийн хамаарал



Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол

2011 онд манай улсын инфляци Хятадын инфляцийн хандлагаас өөр чиглэлтэй байсан нь дотооддоо засгийн газрын зүгээс зохицуулалтын арга хэмжээ авсантай холбоотой. Тухайлбал манай улсын хувьд нөөцийн махыг зах зээлийн үнээс хямдралтай үнээр зарсан нь инфляци буурахад нөлөөлсөн байна.

Хятадын хувьд дэлхийн санхүү эдийн засгийн хямралын үед мөнгөний нийлүүлэлтийг нэмсэн нь хямралын дараагаар инфляци өсөхөд гол нөлөө үзүүлсэн бөгөөд тухайн үед хүнсний бүтээгдэхүүний үнэ мөн нэмэгдсэн байна.


Хятад улсын инфляцийн түвшин манай улсын инфляцийн түвшинд нөлөөлж байгаа эсэхийг гранжерийн учир шалтгааны тест болон скаттер шинжилгээгээр харсан болно¹⁰. Гранжерийн учир шалтгааны тестийн үр дүнгээс харахад Хятадын инфляцийн түвшин Монгол Улсын инфляцийн түвшинд нөлөөлдөг гэсэн үр гарч байна.

Хүснэгт 6. Гранжерийн тест (инфляци)


Гранжерийн тест	F-статистик	Магадлал
Хятадын инфляцийн түвшин Монгол Улсын инфляцид нөлөөлдөггүй	2.67	0.06

Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол


Хятад улс нь дэлхийн зах зээл дээрх нүүрсний үйлдвэрлэл болон хэрэглээний 50 хүртэлх хувийг үйлдвэрлэж, хэрэглэдэг улсын хувьд дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэд нөлөөлөх магадлал улам бүр нэмэгдсээр байна. 2013 оны 1-р сард Монголын засгийн газар болон “Чалко”-гийн хооронд хийсэн гэрээнд асуудал гарсны улмаас манай улсын нүүрсний экспортод тодорхой хэмжээгээр нөлөөлж байна (Зураг 32).

Зураг 32. Нүүрсний экспорт, нүүрсний үнийн индекс


Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Зураг 33. ММС үнийн индексЭх үүсвэр: www.bloomberg.com

Гэрээний маргаантай байдлаас үүдэн Монголын уул уурхайн компаниудын хөрөнгийн бирж дээрх үнийн индекс буурч эхэлсэн сөрөг үр дагавар гарч байна. Мөн түүнчлэн нүүрсний экспорт буурсантай холбоотойгоор гадаад худалдааны тэнцэл ихээхэн алдагдалтай байна. Зураг 34-т Хятад улс руу импортолсон нүүрсний хэмжээг харуулсан бөгөөд 2013 оны эхний улирлын байдлаар 20 сая орчим метрик тонн нүүрс импортолсон байна. Харин Австрали улсын хувьд мөн хугацаанд 70 сая орчим метрик тонн нүүрс импортолжээ.

Зураг 34. БНХАУ-ын нүүрсний импорт

Эх үүсвэр: Блумберг, Хятадын Гааль

Зураг 35. БНХАУ-ын коксжсон нүүрсний импорт, улсаар

Эх үүсвэр: Блумберг, Хятадын Гааль

Хятад улсын коксжсон нүүрсний импорт 2004 оны байдлаар 10 хүрэхгүй сая метрик тонн нүүрс гаднаас импортоор авч байсан бол 2012 оны байдлаар 65 сая орчим метрик нүүрс импортолжээ. Нийт коксжсон нүүрсний импортын 76 орчим хувийг Монгол болон Австрали улс бүрдүүлж байгаа бөгөөд 2010 оны байдлаар Монгол Улс 16.6 сая метрик тонн нүүрс экспортолсон бол 2012 онд 21.7 сая

метрик тонныг гаргасан байна.

2011 оны манай улсын эдийн засгийн өсөлтөд нүүрсний экспорт голлон нөлөө үзүүлсэн бөгөөд цаашид Хятад улс уруу хэдий хэр хэмжээний нүүрсийг ямар үнээр экспортод гаргах уу гэдгээс 2013 оны эдийн засгийн өсөлт ихээхэн хамаарахаар байна.


Шигтгээ 4.

Эдийн засгийн өсөлтийн хамаарал

Зурагнаас харахад 1990-ээд оноос эхлэн 2000-аад оны дунд үе хүртэл Хятадын эдийн засаг хурдацтай өсөхөд аж үйлдвэрийн салбар гол нөлөө үзүүлсэн байна. 2000 оны дунд үеэс эхлэн Хятадын аж үйлдвэрийн салбар тэр дундаа машин тоног төхөөрөмж, барилгын салбар хурдацтай өссөн, дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ нэмэгдсэн зэрэг нь манай улсын эдийн засгийн өсөлтөд гол нөлөө үзүүлсэн байна.


Зураг 36-д хоёр улсын эдийн засгийн өсөлтийн динамикийг харуулсан бөгөөд эдийн засгийн өсөлтүүдийн хооронд хамаарал байгаа эсэхийг гранжерийн учир шалтгааны тестээр шалгасан болно⁶⁶. Шинжилгээгээр Хятадын эдийн засгийн өсөлтийн түвшин манай улсын эдийн өсөлтөд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг гэсэн үр дүн гарсан.

Зураг 36. Эдийн засгийн өсөлтийн хамаарал



Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол

Зураг 37. Эдийн засгийн өсөлт, түүхий эдийн үнэ



Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол

Хямралын үед манай зэсийн гол экспортын түнш орон болох Хятадын дотоод хэрэглээ нь багасч үйлдвэрлэлийн салбарын өсөлт сааран эдийн засгийн өсөлтийн хурд удааширсан, дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ буурснаас шалтгаан Монгол Улсын эдийн засгийн өсөлт буурахад нөлөөлжээ.

Харин хямралын дараагаар нүүрсний экспортын ихэнх хувийг Хятад улс руу гаргасан, дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ өссөн, гадаад худалдааны хамгийн том түнш орны эдийн засаг сэргэсэн зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан 2011 онд манай улсын эдийн засгийн өсөлт **17.5%** гарахад гол нөлөө үзүүлжээ.

Мөн Хятадын аж үйлдвэрлэлийн салбарын өсөлт нь манай улсын эдийн засгийн өсөлтөд нөлөөлдөг эсэхийг тестээр шалгасан. Тестийн үр дүнгээс харахад аж үйлдвэрлэлийн салбарын өсөлтийн түвшин Хятадын эдийн засгийн өсөлтийн түвшнээс илүүтэйгээр манай улсын инфляцийн түвшинд нөлөөлдөг байна.

⁶⁶ Хавсралт 7-11-ээс харна уу.

Хүснэгт 7. Гранжерийн тест (аж үйлдвэр)


Гранжерийн тест	F-статистик	Магадлал
Хятадын аж үйлдвэрийн өсөлт Монгол улсын эдийн засгийн өсөлтөд нөлөөлдөггүй	7.81	0.0045

Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол

6.3. Хөрөнгө оруулалт

Монгол Улсад 1990 оноос хойш хамгийн их хөрөнгө оруулалт хийсэн улс 2012 оны 6-р сарын байдлаар БНХАУ байна. БНХАУ 1990 оноос 3,650.9 сая ам доллар шууд хөрөнгө оруулалт хийсэн ба энэ нь нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 31.7 хувь байна.

Зураг 38. Монгол Улсад бүртгэлтэй БНХАУ-ын хөрөнгө оруулалттай компани



Эх үүсвэр: Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт, бүртгэлийн газар

Зураг 39. БНХАУ-аас Монгол Улсад хийсэн хөрөнгө оруулалт




Эх үүсвэр: Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт, бүртгэлийн газар


Монгол Улсад бүртгэлтэй БНХАУ-ын хөрөнгө оруулалттай компанийн тоо 2012 оны 6-р сарын байдлаар нийт гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын 45.0 хувь буюу хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Шигтгээ 5.**Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт**

БНХАУ-аас Монгол Улсын геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолтын салбарт 1990 оноос хойш оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг аваад үзвэл 2011 оны эцсийн байдлаар 2.5 тэрбум ам. доллар буюу тухайн салбарт оруулсан нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 34.56 хувь байна. БНХАУ-аас Монгол Улсын геологи уул уурхайн салбарт 2005 оноос тасралтгүй хөрөнгө оруулалт хийсэн байгаа ба 2011 оны эцсийн байдлаар хамгийн их хөрөнгө оруулалт хийсэн байна.

Зураг 40. БНХАУ-аас Монгол Улсын геологи, уул уурхайн салбарт оруулсан хөрөнгө оруулалт

Эх үүсвэр: Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт, бүртгэлийн газар


Зураг 41. БНХАУ-аас Монгол Улсын Геологи, уул уурхайн салбарт оруулсан хөрөнгө оруулалт

Эх үүсвэр: Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт, бүртгэлийн газар


Монгол Улсад 2013 оны 4-р сарын эцсийн байдлаар хүчин төгөлдөр 3436 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл байгаа бөгөөд энэ нь нийт нутаг дэвсгэрийн 12.0 хувийг эзэлж байна. Нийт хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн 67.1 хувь нь дотоодын эзэмшигчдийнх бол 23.3 хувь нь гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай, 9.6 хувь гадаадын хамтарсан хөрөнгө оруулалттай байна. Үүнээс Хятадын 100 хувь хөрөнгө оруулалттай 277 ширхэг тусгай зөвшөөрөл байдаг нь нийт тусгай зөвшөөрлийн 8.1 хувийг эзэлж байна. Харин Монгол, Хятадын хамтарсан хөрөнгө оруулалттай 115 тусгай зөвшөөрөл байдаг нь нийт тусгай зөвшөөрлийн 3.3 хувийг эзэлж байна.

6.4. Зам тээвэр, харилцаа холбоо

Монгол Улсын хилийн урт 8252.658 км байдгаас БНХАУ-тай 4709.658 км, 3543 км урт хилээр нийлдэг. Монгол Улсад нийт хилийн 46 боомт байдгаас агаарын боомт 4, автомашины боомт 39, мөн төмөр замын боомт 3 байдаг байна. Монгол Улс, ОХУ-тай хиллэдэг хэсэгт 29, БНХАУ-тай хиллэдэг хэсэгт 13 боомттой.

Зураг 42. Замын-Үүд боомтоор нэвтэрсэн вагоны тоо

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Зураг 43. Хилээр нэвтэрсэн автомашины тоо

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

6.5. Хятадын эдийн засгийн Монгол Улсад үзүүлэх нөлөөлөл

2000 оны 12-р сараас 2013 оны 3-р сар хүртэлх Хятад улсын ДНБ, ХҮИ, нүүрсний үнэ, Монгол Улсын ДНБ, ХҮИ, юань/төгрөгийн ханшийн тоон өгөгдлийг ашигласан. Зарим улирлын нөлөөлөлтэй үзүүлэлтүүдэд улирлын нөлөөллийг засч загварт орууллаа.

Манай улс экспорт болон импортын хувьд Хятад улсаас ихээхэн хамааралтай байгаа тул манай улсын эдийн засгийн бүтцийн загварыг гаргахдаа Хятадын эдийн засгийн үзүүлэлтүүдийг хамт оруулан үнэллээ. Үүнд Хятадын ДНБ болон инфляци Монголын эдийн засагт шууд болон шууд бус нөлөө үзүүлдэг гэж таамаглалаа.

6.5.1. SVAR загварын үнэлгээ

2000-2013 оны хоорондох тоон өгөгдлүүдэд хийсэн шинжилгээнээс үзэхэд Хятадын инфляци өсөхөд Монгол Улсын инфляци бас дагаж өсдөг ба нөлөөлөл нь 5 сарын дараанаас саармагждаг гэсэн дүн гарлаа. Хятад улсын ДНБ болон инфляци өсөхөд нүүрсний үнэ өсдөг байна. Үүнийг Хятад улсад эрэлт нэмэгдэхэд нүүрсний үнэ нэмэгдэх хандлагатай байдаг гэж ойлгож болно.

Хүснэгт 8. Үнэлгээний үр дүн

	Хятадын эдийн засгийн өсөлт	Хятадын инфляцийн түвшин
Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ	Хамааралтай	Хамааралтай
Монгол улсын инфляцийн түвшин		Хамааралтай
Монгол улсын эдийн засгийн өсөлт	Хамааралгүй	

Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол

Үнэлгээний дүнгээр Хятадын эдийн засгийн өсөлт манай эдийн засагт шууд нөлөө үзүүлэх хандлага ажиглагдаагүй байгаа ба бусад үзүүлэлтүүдийн хооронд ач холбогдолтой хамаарал алга байна. Нүүрсний экспортын нийт экспортод эзлэх хувь зөвхөн сүүлийн жилүүдэд нэмэгдсэн учраас регрессийн шинжилгээгээр Монгол Улсын эдийн засагч ач холбогдолгүй гарсан байх талтай⁶⁷.

⁶⁷ Хавсралтаас (7-12) харна уу

ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Энэхүү судалгааны хүрээнд Хятадын эдийн засгийн Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тойм байдлаар судлахыг зорьсон. Хятадын эдийн засгийг тоймлон хэлбэл сүүлийн 30 орчим жил тогтмол хурдацтай өссөн ба энэ нь:

- Аж үйлдвэрийн салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалт ихээр татсан, тэр дундаа экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлд амжилттай оруулсан,
- Ханшийг тогтвортой сул барьж чадсан,
- Шаардлагатай үед төрийн зардлыг ихэсгэх замаар эрэлтийг дэмжин эдийн засгийг тогтворжуулж чадаж байсантай холбон ойлгож болохоор байна.

Юаний ханшийг 10 орчим жил тогтмол түвшинд барьж байснаа 2005 оноос эхлэн аажмаар чангаруулж эхэлсэн. Үүний үр дагавраар:

- Хятадын экспортын өрсөлдөх чадвар суларсан
- Дэлхий нийтэд өргөн хэрэглээний бараа илүү өндөр үнэтэйгээр нийлүүлэгдэх болсон
- Хүн хүч давамгайлсан үйлдвэрлэл хөгжүүлэх сонирхолтой Филиппин, Индонез зэрэг улсуудад боломж бий болсон.

Юаний ханш чангарсан, иргэдийн орлого нь нэмэгдсэн зэрэг хүчин зүйлсээс харахад Хятадын эдийн засаг үйлдвэрлэн нийлүүлэгч эдийн засгийн хэв маягаас аажмаар хэрэглэгч эдийн засаг болох төлөв рүү шилжиж байна.

Монгол Хятад улсуудын эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байна. Үүний илрэл нь:

- Монгол Улсын нийт экспортын 91%-ийг, импортын 28 хувийг дангаараа Хятад улс эзэлж байна.
- Хятад улс нь Монгол Улсын хамгийн том хөрөнгө оруулагч ба хөрөнгө оруулалтын ихэнх хувийг уул уурхайн салбарт оруулж байна.
- Хоёр улсын хооронд худалдаа, хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаатай зэрэгцэн хилийн тээвэр, аялал жуулчлалын салбар цаашид эрчимтэй тэлэх хандлагатай байна. Монгол Улсын хилээр нэвтэрсэн нийт иргэдийн 60% нь Хятад улсын иргэд байна.

Монгол Улсын эдийн засаг дан ганц уул уурхайн бүтээгдэхүүнээс хамааралтай байгаа нь санаа зовинуулах асуудал ч дан ганц худалдан авагчтай байх нь түүнээс ч илүү анхаарууштай асуудал юм.

- Хэдийгээр Монгол Улс Хятад улсын хамгийн том нүүрс худалдаалагч орнуудын нэг боловч Монголын нүүрсний экспорт Хятадын нүүрсний

хэрэглээний 0.5-0.6% төдий л байна.

- Хятадын эдийн засгийн өсөлт, манай улсын экспортын гол бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээл дээрх үнээс хамаарч манай улсын эдийн засгийн өсөлт өөрчлөгдөж байна.

Өргөн хэрэглээний бүтээгдэхүүний ихэнх хувийг Хятад улсаас импортоор оруулж ирж байгаа нь Хятадын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт манай улсын инфляцийн түвшинд нөлөө үзүүлэх гол суваг болж байна.

- Гранжерийн учир шалтгааны тестээр хоёр улсын инфляцийн хамаарлыг шалгаж үзэхэд Хятадын инфляциас Монголын инфляци руу чиглэсэн хамааралтай байгаа нь ажиглагдсан.
- Мөн бүтцийн ВАР загвар ашиглан шинжилгээ хийж үзэхэд Хятад улсын инфляци өсөхөд манай улсын инфляци даган өсдөг ба 5 сарын дараа нөлөө нь саармагждаг байна.

Бүтцийн ВАР загварын хувьд:

- Хятад улсын ДНБ болон инфляци өсөхөд дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ нэмэгддэг гэсэн дүн гарлаа. Үүнийг Хятад улсад эрэлт нэмэгдэхэд дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ нэмэгдэх хандлагатай байдаг гэж ойлгож болно. Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ нэмэгдсэнээр манай улсын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нь эерэг байх талтай.

Уг судалгаагаар Хятадын эдийн засгийн талаарх тойм судалгааг хийсэн бөгөөд цаашид Хятадын эдийн засгийн талаар нарийвчилсан судалгаа хийж түүний монгол улсад үзүүлэх нөлөөллийг харуулахыг зорьж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Economist Corporate Network. (2011). *The 12th Five-Year Plan: China's Economic Transition*. Shanghai.

Barry, N. (2007). *The Chinese Economy: Transitions and Growth*. London: MIT Press.


Kaufmann, D. (2005). *Myths and Realities of Governance and Corruption*. New York: World Economic Forum.

Morrison, W. M. (2013). *China's Economic Rise: History, Trends, Challenges, and Implications for the United States*. Washington: Congressional Research Service.

The Economist Intelligence Unit. (2013). *World commodity forecasts: industrial raw materials*. London: Economist Intelligence Unit.


ХАВСРАЛТ

Хавсралт 1. Хүн амын насны суварга (1996)




Эх үүсвэр: Хятадын статистикийн газар

Хавсралт 2. Дотоодын нийт бүтээгдэхүүн

Эх үүсвэр: www.data.worldbank.org

Хавсралт 3. Эдийн засгийн өсөлт (салбараар)




Эх үүсвэр: Хятадын статистикийн газар (2011)

Хавсралт 4. Эдийн засгийн өсөлт (зардлын аргаар)




Эх үүсвэр: Хятадын статистикийн газар (2011)

Хавсралт 5. Дотоодын зээл (цэвэр)


Эх үүсвэр: www.data.worldbank.org

Хавсралт 6. Хөрөнгө, банкны системийн нийт актив




Эх үүсвэр: OECD Economic Surveys China (2013)

Хавсралт 7. Монгол Улсын Хятад улстай хийсэн худалдааны тэнцэл



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Хавсралт 8. Монгол Улсын гадаад худалдаа (улсаар)




Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Хавсралт 9. Монгол Улсаас БНХАУ-д экспортлосон



Эх үүсвэр: Блумберг, Хятадын Гааль

Хавсралт 10. Инфляцийн хамаарал







Хавсралт 11. Гранжерийн тест (эдийн засгийн өсөлт)

Гранжерийн тест	F-статистик	Магадлал
Хятадын ЭЗ-ийн өсөлт Монгол улсын эдийн засгийн өсөлтөд нөлөөлдөггүй	7.61	0.05


Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол

Хавсралт 12. SVAR загварын үнэлгээ



Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол

Хавсралт 13. Улсын хилээр нэвтэрсэн БНХАУ-ын иргэд



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Хавсралт 14. Улсын хилээр орсон жуулчдын тоо



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо